



БАРИЛГА,  
ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН  
ТУШААЛ

2016 оны 12 сарын 08 өдөр

Дугаар А/193

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Барилгын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.11 дэх заалт, Улсын Их Хурлын 2016 оны 34 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Барилгын материалын туршилт, шинжилгээ судалгааны ажил эрхлэх нэгдсэн лабораторийн дүрэм"-ийг хавсралтаар баталсугай.

2."Барилгын материалын туршилт, шинжилгээ судалгааны ажил эрхлэх нэгдсэн лабораторийн дүрэм"-ийг холбогдох байгууллагад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Занабазар/, "Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ /Ц.Амарсанаа/-д тус тус даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийн талаар Сайдын зөвлөлд жил бүр танилцуулж байхыг Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Занабазар/, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоодын аудитын газар /Н.Нарантуяа/-т үүрэг болгосугай.


САЙД



Г.МӨНХБАЯР

08 00618

Барилга хот байгуулалтын сайдын 2016  
оны 18 дүгээр сарын 08 -ны өдрийн  
А/193 дугаар тушаалын хавсралт



**БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ТУРШИЛТ,  
ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ АЖИЛ ЭРХЛЭХ  
НЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН ДҮРЭМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1.Энэ дүрмээр барилгын материалын туршилт, шинжилгээ судалгааны ажил эрхлэх нэгдсэн лабораторийн үйл ажиллагааны ажиллах зарчим, бүтэц, зохион байгуулалт, хамрах хүрээ, туршилт, шинжилгээ судалгааны ажил гүйцэтгэх дэс дараалал, ажилтны хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны харилцааг зохицуулна.

1.2.Барилгын материалын туршилт, шинжилгээ судалгааны ажил эрхлэх нэгдсэн лаборатори нь шинжилгээний үйл ажиллагаандаа Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, норм нормативын баримт бичгийг мөрдөж ажиллана.

1.3.Барилгын материалын туршилт, шинжилгээ судалгааны ажил эрхлэх нэгдсэн лаборатори нь барилгын материал, хийц бүтээц, түүний түүхий эдүүдэд физик, механикийн шинж чанарын үзүүлэлтүүд стандартын шаардлагыг хангаж байгаад туршилт, шинжилгээ судалгаа хийж дүгнэлт гаргах ажлыг эрхэлнэ.

1.4.Барилгын материалын туршилт, шинжилгээ судалгааны ажил эрхлэх нэгдсэн лаборатори сорил шинжилгээний дүгнэлтийг ил тод, хараат бус, нууцлалыг хангаж гүйцэтгэнэ.

1.5.Барилгын материалын туршилт, шинжилгээ судалгааны ажлын хөлс, үйлчилгээний үнэ, тарифыг Барилгын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2-т заасны дагуу Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулж, мөрдөнө.

**Хоёр. Бүтэц зохион байгуулалт, байршил**

2.1.Барилгын материалын туршилт, шинжилгээ судалгааны ажил эрхлэх нэгдсэн лаборатори нь нийслэл болон аймаг, орон нутгийн лабораториудаас бүрдэнэ.

2.2.Нийслэлд үйл ажиллагаа эрхлэх барилгын материалын нэгдсэн лабораторийг “Барилгын материалын сорил шинжилгээний лаборатори” гэж нэрлэнэ.

2.3.Аймгийн төвүүд болон орон нутагт үйл ажиллагаа эрхлэх лабораторийг “Барилгын материалын лаборатори” гэж нэрлэнэ.

2.4.Барилгын материалын сорил шинжилгээний лаборатори нь аймаг, орон нутгийн барилгын материалын лабораториудын үйл ажиллагааг мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана.

2.5.Энэ дүрмийн 2.2, 2.3-д байгаа лаборатори зөвхөн туршилт, шинжилгээний үр дүнг баталгаажуулах албан бичгийн хэвлэмэл хуудас болон дардастай байна.

2.6.Албан бичгийн хэвлэмэл хуудас, шинжилгээний дүнг баталгаажуулах дардасны загварыг тухайн лабораторийг харъяалах хуулийн этгээдийн шийдвэрээр баталгаажуулна.

2.7.“Барилгын материалын сорил шинжилгээний лаборатори” нь Улаанбаатар хотын Сонгино хайрхан дүүргийн 20 дугаар хороонд байрлана.

2.8.Аймгийн мэргэжлийн хяналтын газрын харъяанд орон нутгийн лаборатори үйл ажиллагаа эрхэлнэ.

#### **Гурав.Лабораторийн үйл ажиллагааны хамрах хүрээ**

3.1.Лаборатори “Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага” стандартын дагуу чанарын гарын авлага боловсруулж мөрдөж ажиллана.

3.2.Барилгын материалын туршилт, шинжилгээний судалгааны ажил эрхлэх нэгдсэн лаборатори дараах төрөлжсөн лабораториудтай байна:

3.2.1.хими

3.2.2.металл эдлэхүүн

3.2.3.бетон дүүргэгч материал

3.2.4.цемент, холбогч материал

3.2.5.керамик эдлэхүүн

3.2.6.будаг

3.2.7.хуванцар эдлэл

3.2.8.хаалга, цонх

3.2.9.хөрс

3.2.10.барилгын физикийн/рентген шинжилгээний/

3.2.11.газар хөдлөл

3.2.12.төмөр бетон хийц эдлэхүүн үйлдвэрлэлийн туршилт

3.2.13.өргөх машин механизм, цахилгаан утас

3.3.Орон нутгийн “Барилгын материалын лаборатори” нь дараах төрлийн лабораториудтай байна:

3.3.1.бетон, дүүргэгч материал

3.3.2.цемент, холбогч материал

3.3.3.будаг

3.3.4.хаалга, цонх

3.3.5.хөрс

3.3.6.металл эдлэхүүн

3.4.Барилгын материалын туршилт, шинжилгээ судалгааны ажил эрхлэх нэгдсэн лаборатори нь аймаг, орон нутгийн лабораторийн ажилчдыг сургаж, дадлагажуулж, стандартаар хангах ажлыг хийж гүйцэтгэнэ.

#### **Дөрөв. Лабораторийн ажил гүйцэтгэх дараалал**

4.1.Барилгын ажилд хэрэглэгдэх түүхий эд, материал, хийц, бүтээцийн загвар, дээжийг хүлээн авч бүртгэх сорил шинжилгээ хийх, үр дүнг баталгаажуулах, захиалагчдад хүлээлгэн өгөх дарааллаар лабораторийн үйл ажиллагаа хийгдэнэ.

4.2.Лаборатори нь энэ дүрмийн 4.1-д заасан үйл ажиллагааг эрхлэхдээ “Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага” стандартын шаардлагыг мөрдөж ажиллана.

4.3.Сорил шинжилгээний ажлыг доорх дэс дарааллаар гүйцэтгэнэ:

4.3.1.Хүлээн авах бүртгэх үйл ажиллагааг лабораторийн ахлах шинжээч тусгай нууцлал бүхий дугаар олгож тэмдэглэлд бүртгэх;

4.3.2.Туршилт, сорилт, шинжилгээний ажлыг гүйцэтгэж үр дүнг тооцож гаргах;

4.3.3.Туршилт сорилтын ажлыг ахлах шинжээчээс тухайн нэгж лабораторид шинжээч томилон хараат бусаар стандартын хүрээнд туршилт шинжилгээг хийж гүйцэтгэх;

4.3.4.Шинжээчийн гаргасан шинжилгээний ажлын үр дүнг ахлах шинжээч хянаж, шинжилгээний ажлын төлбөр хийгдсэн эсэхийг нягталсны дараа шинжилгээний эцсийн дүнг дугаарлал бүхий нууцлалтай хэвлэмэл хуудас дээр хэвлэн гарын үсэг зурж, лабораторийн эрхлэгчээр батлуулан дардас дарж албажуулах;

4.3.5.Барилгын материалын лабораторид хийгдсэн сорилт, шинжилгээний дүнгийн хэвлэмэл хуудасны тооцоог санхүүд акт үйлдэн хүлээлгэн өгч, дагалдах баримтын хамт хүлээн авах;

4.3.6.Лабораторид хийгдсэн туршилт, шинжилгээний үр дүнг хянан баталгаажуулж нэг хувийг захиалагч үйлчлүүлэгчид олгоно.

4.4. Лабораторийн сорил шинжилгээний зарим ажлыг ажлын байрнаас өөр газар доорх дэс дарааллаар хийж гүйцэтгэнэ:

4.4.1.Лабораторийн туршилтын ажлыг барилгын талбайд хийх сорилт, шинжилгээний ажлыг гүйцэтгэхдээ харилцагчийн хүсэлтийг лабораторийн эрхлэгчид албан бичгээр тавьж, шийдвэрлүүлэх;

4.4.2.Чанарын менежер харилцагчдын хүсэлтээр хийгдэх барилгын зураг болон бусад холбогдох баримт бичигт тулгуурлан хийгдэх сорилт, туршилт, шинжилгээний ажлыг тухайн лабораторийн шинжээчээр гүйцэтгүүлэх;

4.4.3.Сорилт шинжилгээний ажил гүйцэтгэх гэрээг тухай бүр байгуулж, ажлын хөлс төлсөн баримт, холбогдох материалыг гэрээнд хавсаргах;

4.4.4.Гүйцэтгэсэн ажлын туршилт, сорилт, шинжилгээний ажил дууссанаас хойш ажлын 3 хоногт багтаан хариуцсан шинжээч лабораторийн эрхлэгчээр баталгаажуулан хариуг олгох;

4.4.5.Туршилт сорил шинжилгээний ажлын хөлсийг Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан тарифын дагуу тооцох.

#### **Тав. Лабораторийн үйл ажиллагаанд оролцогчдын чиг үүрэг**

5.1.Лабораторийн эрхлэгч, чанарын менежер дараах чиг үүргийг хэрэгжүүлж ажиллана:

5.1.1.Чанарын удирдлагаар хангахын зэрэгцээ Барилгын материалын сорилт, шинжилгээний лабораторийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

5.1.2.Барилгын материалын лабораторийн үйл ажиллагааг байнгын тасралтгүй, шуурхай удирдлагаар хангах, дотоодын үйл ажиллагааны уялдаа холбоог зохицуулах, зохион байгуулах, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангаж, нийт ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгааг биечлэн авч байгаа эсэх, нормын хувцас, хэрэгслийг хэрэглэж буй эсэх, хариуцсан ажилтан зааварчилгааг цаг тухай бүрт өгч байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж ажиллах;

5.1.3.Барилгын материалын лабораторийн эрхлэх үйл ажиллагааны үр дүнгээр байгууллагын хууль тогтоомжийн хүрээнд удирдлага болон захиалагч, үйлчлүүлэгчийн өмнө хариуцлага хүлээх;

5.1.4.Барилгын материалын лабораторийн үйл ажиллагааны жил, улирал, сарын нэгдсэн төлөвлөгөө боловсруулж батлуулан, гүйцэтгэлийг сар, улирал, жилээр тайлагнаж ажлаа дүгнүүлэх;

5.1.5.Барилгын материалын лабораторийн ажиллагсдыг төлөөлж байгууллагын удирдлага болон бусад нэгжтэй харьцах, гэрээ хэлцлийн төсөл боловсруулах, шинжилгээ, туршилтын үр дүнг батлах, бүтэц, бүрэлдэхүүн, үйл ажиллагаа, боловсон хүчний талаар саналаа гаргаж шийдвэрлүүлэх;

5.1.6.Барилгын материалын лабораторийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх шаардлагатай стандарт, норм, дүрэм, бусад хууль тогтоомжоор хангуулах, мэргэжлийн шинжээч ажиллагсдыг мэргэшүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх саналыг удирдлагад тавьж шийдвэрлүүлэх;

5.1.7.Барилгын материалын лабораторийн сорилт, шинжилгээний ажилд байгууллагын удирдлагын зөвшөөрлөөр тухайн чиглэлээр мэргэшсэн дадлага туршлага бүхий эрдэмтэд зөвлөхүүдийг гэрээгээр ажиллуулах.

5.2.Техникийн менежер, ахлах шинжээч /цаашид ахлах шинжээч гэх/-ийн дараах чиг үүрэгтэй ажиллана.

5.2.1.Техникийн удирдлагаар хангах бөгөөд нэгж лабораторийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж, дүрмийн 4 дүгээр бүлэгт заасан ажлын дарааллын дагуу үйл ажиллагаагаа төлөвлөн хэрэгжүүлэх бөгөөд харилцагч, үйлчлүүлэгчдийн талаарх мэдээллийг нууцлах;

5.2.2.Лабораторийн эрхлэгчид шинжилгээний явцыг хянаж, гарсан өөрчлөлт болон хүндрэлийн талаар цаг алдалгүй мэдээлж, алдааны шалтгааныг тогтоох, алдааг залруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар хамтран ажиллах;

5.2.3.Лабораторийн холбогдолтой асуудлыг биечлэн хариуцаж, шаардлагатай асуудлуудыг чанарын менежерт тавьж шийдвэрлүүлэх;

5.2.4.Техник, тоног төхөөрөмж, хөдөлмөр хамгааллын инженерийн ажлыг орон ажиллах, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгааг нийт ажилтанд өгөх, бүртгэл хөтлөх, түүнтэй холбоотой үүссэн харилцааг зохицуулах;

5.2.5.Сорилт, туршилтын эцсийн үр дүн чанарыг захиалагчийн өмнө бүрэн хариуцах;

5.3 Лабораторийн шинжээч дараах чиг үүрэгтэй ажиллана:

5.3.1.Ахлах шинжээчээс кодолсон захиалагчийн дээжийг хүлээн авч ажлын дэвтэрт бүртгэн, сорилт, туршилтыг батлагдсан стандартын арга аргачлалын дагуу гүйцэтгэн туршилтын ажлын явц, үр дүнг лабораторийн ажлын дэвтэрт бичиж тэмдэглэхээс гадна цахим хэлбэрээр компьютерт хадгалан чанарын менежерийг өдөр тутмын мэдээллээр хангах;

5.3.2.Шинжилгээний ажлын үр дүнгийн нууцлалыг хадгалах;

5.3.3.Лабораторийн багаж, тоног төхөөрөмжийг зааврын дагуу бүрэн эзэмшиж тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллах;

5.3.4.Лабораторийн батлагдсан чанарын гарын авлагыг мөрдөн ажиллах;

5.3.5.Лабораторийн шинжилгээтэй холбоотой шинэ арга аргачлалыг боловсруулах ажилд оролцох;

5.3.6.Лабораторийн ажлын байрнаас гадуур харилцагчийн хүсэлтээр, томилолтоор хийх сорилт, туршилт, шинжилгээний ажлыг гүйцэтгэхдээ ажил олгогчийн зүгээс хангасан ажлын хувцас, хамгаалах хэрэгслийг байнга ашиглах;

5.4. Тоног төхөөрөмж, хөдөлмөр хамгааллын инженер дараах чиг үүрэгтэй ажиллана

5.4.1.Тоног төхөөрөмжийн хэвийн аюулгүй ажиллагааг хангах, шинэ техник тоног төхөөрөмж суурилуулах, ашиглалтын зааврыг тухайн тоног төхөөрөмжийг эзэмшигчид хүлээлгэн өгөх;

5.4.2.Лабораторийн тоног төхөөрөмжийн засвар, техникийн үйлчилгээг лабораторийн эрхлэгчийн баталсан графикийн дагуу хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэх;

5.4.3.Лабораторийн багаж, тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай үйл ажиллагааг хангах, техникийн паспортыг хөтлөх, техник ашиглалтын зааврыг тоног төхөөрөмж бүрт байрлуулах ажлыг зохион байгуулах;

5.4.4.Тоног төхөөрөмжийн хаалт хамгаалалт, цахилгаан хөдөлгүүр түүний дамжуулах эд ангийн бүрэн бүтэн байдлыг хянах, аюулгүй ажиллагааг хангах;

5.4.5.Сорилт, шинжилгээний ажил эхлэхээс өмнө лабораторийн тоног төхөөрөмжүүдийн хэвийн ажиллагаа хангагдсан эсийг шалгах;

5.4.6.Нийт ажилтнуудад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгааг өдөр бүр, шаардлагатай тохиолдолд тухайн үед нь зааварчлагаа өгч ажилтнуудаар баталгаажуулах;

5.4.7.Хөдөлмөр хамгааллын санамж, зурагт хуудсыг лабораторийн өрөө тасалгаанд байрлуулах;

5.4.8.Лабораторийн ажлын байрнаас гадуур, харилцагчийн хүсэлтээр сорилт, шинжилгээ хийхээр томилогдсон ажилтанд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгч, гарын үсэг зуруулан баталгаажуулна;

5.4.9.Өндөр үнэ бүхий тоног төхөөрөмжийг эвдрэл гэмтлээс урьдчилан сэргийлэх үүднээс даатгуулах;

#### **Зургаа. Лабораторийн ажилтнуудын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа**

6.1.Ажилчдын аюулгүй нөхцөлд ажиллахыг чанарын менежер хангаж ажиллана.

6.2.Лабораторийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааг хангах, ажилчдын аюулгүй ажиллагаанд сургаж дадлагажуулахыг хөдөлмөр хамгааллын инженер хариуцаж гүйцэтгэнэ.

6.3.Эрдэс химийн лабораторийн аюулгүй ажиллагааг дараах байдлаар хангаж ажиллана.

6.3.1.Рентген төхөөрөмж дээр ажиллахдаа түүний бүтэц байгууламж ашиглалтын үед гарч болзошгүй осол, рентген туяаны хорт үйлчилгээ, өндөр хүчдэлээс үүсэж болох аюул, ослын тухай мэдлэгтэй байх;

6.3.2.Рентген тоног төхөөрөмжийг суурилуулах, угсрах, засварлах ажлыг зөвшөөрөгдсөн байгууллага, мэргэжлийн хүмүүсээр гүйцэтгүүлэх;

6.3.3.Рентген туяаны хамгаалалт нь туяаны чадлыг боломжит дээд хэмжээгээр сулруулсан байхаар тооцно. Ажлын байранд хордолтын зөвшөөрөгдөх хэмжээ долоо хоногт 100 мт /жилд 5-р/ -аас хэтрэхгүй байх тооцох;

6.3.4.Рентген хоолойн ашиглагдахгүй байгаа цонхнуудыг 1 мм-ээс багагүй зузаантай хар тугалган хаалтаар найдвартай хаах;

6.3.5.Дифрактометррийн гониметрийн төхөөрөмжинд хар тугалгатай резинэн цилиндр хэлбэртэй хаалт хийх ба ажиллах үед бүрэн хаасан байх;

6.3.6.Бүх төхөөрөмжүүд найдвартай газардуулгатай байна. Төхөөрөмжийн рентген хоолойг чийгтэй гараар барихыг хатуу хориглоно.

6.4.Бетон, төмөр бетоныг үл эвдэх аргаар шинжлэх үеийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг доорх байдлаар хангаж ажиллана

6.4.1.Багажаар үл эвдэх аргаар сорил шинжилгээ хийхийн өмнө хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа авч, гарын үсгээр баталгаажуулах;

6.4.2.Бетон, төмөр бетоныг үл эвдэх аргаар сорил шинжилгээг хийхдээ хоёроос доошгүй шинжээчийг ажиллуулах;

6.4.3.Өндөр нь 1.5 м-ээс дээш бетон хийцэд шинжилгээ хийхэд захиалагч байгууллага хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангаж нэмэлт хүн хүч гаргаж өгөх;

6.4.4.Захиалагч байгууллага тухайн шинжилгээ хийх үеийн ажлын талбарын аюулгүй ажиллагааг хангаж, ажиллах нөхцлийг бүрдүүлсэн байх;

6.4.5.Тухайн багажны алхыг бие дээрээ туршихыг хориглох;

6.4.6.Тус үл эвдэх багажны сорилтын алхыг бетон эдлэхүүнээс өөр хийц эдлэл дээр туршихыг хориглох; /металл болон нягтруулсан хатуулаг өндөр материалд/

6.4.7.Багажийг -200-аас +30<sup>0</sup>С цельсийн нөхцөлд ажиллуулах;

6.4.8.Ус болон өндөр чийгшилтэй орчинд ажиллуулахыг хориглох;

6.4.9.Шинжээч 1.5 м-ээс өндөрт ажиллах үед урьдчилан бэхлэгдсэн найдвартай хийц бүтээцээс хамгаалалтын бүсээр бэхлэгдсэн байх;

6.4.10.Мэдээллийг хүлээн авах дэлгэцийг өндрөөс унахаас хамгаалан өөрийн биед зорилтын дагуу бэхэлсэн байх;



6.5.Лабораторийн ажилтнуудад дараах зүйлсийг хориглож ажиллана.

6.5.1.Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилга авахгүйгээр ажилд орох, хөдөлмөр хамгааллын хувцас, хамгаалах хэрэгслийг бүрэн хэрэглэхгүй байх;

6.5.2.Шинжилгээ, туршилтын ажил дууссаны дараа тоног төхөөрөмж болон ажлын байрыг цэвэрлэж, дараагийн ажлын өдөрт бэлтгэсэн байх;

----- о О о -----